



БАТЛАВ.
МӨРӨН СУМЫН ЗАСАТ
ДАРГА *Х. ТАЙВАНБАЯР*

МӨРӨН СУМЫН ТӨВЛӨРСӨН ХОГ ХАЯГДЛЫН ЦЭГТ БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ
ХИЙХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.08.23

Мөрөн сум

| № | Ажлын нэр | Тайлбар |
|----|------------------------|--|
| 1. | Үндэслэл | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.3.4, 9.3.10 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 08 дугаар тэмдэглэл, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 26-ны 04 дүгээр албан даалгавар, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 04 дугаар тогтоол, Аймгийн засаг даргын 2024 оны 5 дугаар сарын 8-ны А/234 дүгээр захирамжийн дагуу хэрэгжилтийг хангах, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/554 дүгээр тушаалт |
| 2. | Зорилго | Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 13 дугаар багийн нутагт орших Элстийн арын “Хог хаягдлын төвлөрсөн цэг-ийн 100 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийх |
| 3. | Хамрах хүрээ | Хог хаягдлын төвлөрсөн цэг |
| 4. | Ажил гүйцэтгэх хугацаа | 2 үе шаттай. 1. 2024 оны 10 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дугаар сарын 01-ны өдрийн хооронд 2. 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийн хооронд |
| 5. | Ажлын даалгавар | <p>Нэгдүгээр үе шат. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">Дээрх талбайн хог хаягдлыг цэвэрлэхХөрс бэлтгэлийн ажил <p>Хоёрдугаар үе шат Үүнд:</p> <ol style="list-style-type: none">Талбайг бэлтгэн хөрсжүүлэхМод тарихУсалгаажуулалт хийх <p>Нийт 12 га талбайд мод тариалах. Тухайн хөрсний шинж чанарт тохируулан мод бут, ургамалыг нөхөн мэргээлтийн стандарт болон тарихад сонгосон модны ургалтын хөгжилд тохирохуйц шимт хөрсөөр дүүргэлт хийсэн нүхэнд мод суулгацыг суулгана. Тариалах мод манай орон нутгийн байгалийн бүс бүслүүрийн онцлогт тохирсон, хөрсний бүтэц найрлага, газрын гадаргын налуу, орчны төлөв байдалд тохирсон 1 метрээс доошгүй, 4-өөс дээш настай суулгацыг 1га талбайд 1500 ширхэгээр тооцон тариална. / Улиас, Хайлаас гэсэн 2 төрлийн мод тариалах/</p> <p>-Нөхөн сэргээлтийн ажлын явцад нөхөн сэргээлт хийж байгаа талаар 1*5:2*0 метр болон түүнээс дээш хэмжээтэй 3 ширхэг</p> |

| | | |
|----|-------------------------|--|
| | | <p>мэдээллийн самбарыг ажлын талбайд байршуулна.</p> <ul style="list-style-type: none"> - Мод тарих хэсэг болон ойр орчмын талбайн хог хаягдлыг цэвэрлэх - Нөхөн сэргээлтийн талбайд суулгах мод суулгацыг холбогдох стандартын дагуу хадгалагдаж, тээвэрлэгдэж, суулгагдсан байх. - Тариалах талбайн шимт хөрс нь 2-с дээш жилийн хугацаагаар хадгалагдаж хөрсний шимт чанар алдагдсан байх тул хөрсөнд шим тэжээл өгөх бордоо, талбайн бэлтгэл усалгаа, тариалалтын явцын усалгаа, цэнэг усалгаа зэргийг ажил гүйцэтгэгч тал хариуцна. - Худаг гаргаж дуслын усалгааны системийг холбох |
| 6. | Тусгай шаардлага | <p>Мэргэжил, ур чадварын дараах шаардлага тавигдана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тус ажилд шаардагдах мэргэжлийн хариуцсан ажлаа чанартай, богино хугацаанд гүйцэтгэх - Мэргэжлийн инженер, техникийн ажилчид байна. - Мэргэжлийн ажилчид гэрээт ажилчин байж болно. - Газрын хэвлэлийн нөхөн сэргээлт, Биологийн нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөлтэй байна. - Ижил төстэй ажлын - Биологийн нөхөн сэргээлт хийх Үйлчилгээг “Уул уурхайн Үйлдвэрлэлийн Үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” хийх тухай MNS-5917-2008 стандарт, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/138 тоот тушаалаар батлагдсан “Уул уурхайн Үйлдвэрлэлийн Үйл ажиллагаагаар эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэнэ. - Ажилд тавигдах шаардлагын дагуу скиз зураг бэлтгэж, ажлын төлөвлөгөө үе шатны хуваарь, мэргэшсэн төсөвчнөөр төсөв батлуулж төндерийн баримт бичигт ирүүлнэ. |
| 7. | Хүлээгдэж байгаа үр дүн | Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 13 дугаар багийн нутагт орших Элстийн арын “Хог хаягдлын төвлөрсөн цэг-ийн 100 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. |
| 8. | Захиалагч байгууллага | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам /Улсын төсвийн хөрөнгөөр/ |
| 9. | Шаардагдах санхүүжилт | 800,000,000.00 / найман зуун сая/ |

Ажлын даалгавар боловсруулсан

Ажлын хэсгийн ахлагч:

(Ч.Батсүх)

Нарийн бичгийн дарга:

(Б.Анхцэцэг)